



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС
ЗҮЙН ХЯНАЛТЫН ХОРОО

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Олимпын гудамж, Засгийн газрын VIII байр
Утас: 263846, И-мэйл: ethics@moh.gov.mn
<http://ethics.mohs.mn>

2017. 11. 03 № 64
танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо нь эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах чиг үүрэгтэй.

Сүүлийн үед иргэд, байгууллага, эмч, эмнэлгийн мэргэжилтнээс мэргэжлийн ур чадвар, ёс зүй, харилцаа хандлагын талаар гомдол, санал ирдэг болсоноос гадна хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр дамжуулан эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуудлыг хөндөх боллоо. Иймд чиг үүргийн хүрээнд ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор энэхүү зөвлөмжийг боловсруулан хүргүүлж байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Дүрэм батлах тухай” 256 дугаар тушаалын дагуу эрүүл мэндийн байгууллага бүр дэргэдээ эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороотой байх бөгөөд тухайн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн холбогдолтой асуудлыг харъяалан шийдвэрлэхийг заасан. Иймд ёс зүйн хороо байгуулаагүй эрүүл мэндийн байгууллага бүр тус хороог байгуулж, хорооны бүрэлдэхүүнийг дүрэмд заасны дагуу батлуулан, үйл ажиллагааг албажуулан дэмжиж ажиллах,

2. Ёс зүйн салбар хороо нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, “Зөрчлийн тухай”, “Эрүүгийн хууль”, “Төрийн болон албаны нууцын тухай” хуулийг байгууллагын бүх эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сурталчлах, мэргэжлийн сургалтыг зохион байгуулах, ёс зүйн зөрчилөөс урьдчилан сэргийлж эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгч, тэдний гэр бүлд хандсан үр дүнтэй сургалт, мэдээллийг тогтмол зохион байгуулах,

3. Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр дамжуулан мэдээлэл, мэдэгдэл хийх тохиолдолд Эрүүл мэндийн сайдын 2013 оны “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг шинэчлэх батлах тухай” 446 дугаар тушаалд үйлчлүүлэгчийн нууц, нууцыг санаатай болон санаандгүй задруулахгүй байх гэж заасныг мөрдөх, хэрэв

0 0146

үйлчлүүлэгчийн нууцыг задруулсан тохиолдолд “Хувь хүний нууцын тухай”, “Зөрчлийн тухай” хуулийн дагуу хариуцага хүлээлгэдэг болохыг анхаарах,

4. Эмнэлгийн мэргэжилтэн нь үйл ажиллагаандаа байгууллагын дотоод журам, тусламж, үйлчилгээний удирдамж, зааврыг мөрдөхийг заасан тул хориглосон үйл ажиллагааг үзүүлэхгүй байхад анхаарах, “Эрүүл мэндийн тухай” хуулийн 28 дугаар зүйлд заасан эмнэлгийн мэргэжилтний үүргийг биелүүлэх,

5. Аливаа дүгнэлтийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулахдаа “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 1.3-т “хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай бол мэдээллийг бусдад задруулахыг хориглоно” гэж заасныг мөрдөх,

6. Эрүүл мэндийн байгууллагын удирдах албан тушаалтнууд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдөхөөс гадна Эрүүл мэндийн сайдын 2013 оны “Эмнэлгийн мэргэжилтийг ёс зүйн хэм хэмжээг шинэчлэн батлах тухай” 446 дугаар тушаалын 3.8-д заасан нэмэлт ёс зүйг баримтлах, мөрдөх, өөрөөс шалтгаалан ёс зүйн зөрчил гаргахгүй байхад анхаарах,

7. Эрүүл мэндийн сайдын 2013 оны “Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг шинэчлэн батлах” тухай 446 дугаар тушаалын 3.4-т зааснаар эмнэлгийн мэргэжилтэн мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлж, мэргэжлийн болон ёс зүйн алдаа гаргахгүй байхад анхаарч, шинээр боловсруулан гарч буй стандарт, дүрэм, журам, тушаал, эмнэлзүйн заавартай цаг тухай бүрт танилцаж, эмнэлгийн тусламж, үйлчилгээг мэргэжлийн зан үйл, итгэл үнэмшилээр хийж хэвших,

8. Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтныг сонгон ажилуулахдаа Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооноос гаргадаг ёс зүйн зөрчилгүйг баталсан тодорхойлолтод үндэслэн сонгон шалгаруулалтыг хийх.

Энэхүү зөвлөмжийг харъяалах бүх шатны эрүүл мэндийн байгууллагад хүргэж ажиллана уу.

Жич: Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны гаргасан дүгнэлт, санал, зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтэн бүр дагаж мөрдөхийг үүгээр уламжилж байна.

ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН ХЯНАЛТЫН
ХОРООНЫ ДАРГА



Д.ЦЭРЭНДАГВА